



ИТГЭМЖЛЭЛ ИЛГЭЭХ ЗААВАР:

1. Та нотариатын танхимын <https://consul.notary.mn/login> хаягаар нэвтэрч орно **/Компьютер ашиглан нэвтэрч орохыг зөвлөж байна/**
2. Өөрийн нэр, регистрийн дугаар, и-мэйл хаяг дээр шинээр хаяг үүсгэнэ **Зөвхөн Монгол Улсын иргэн тус системд бүртгүүлэх боломжтой.** Гадаад Улсын иргэн болон түр оршин суух үнэмлэхтэй иргэд Ерөнхий консулын газарт өөрийн биеэр ирж итгэмжлэл хийнэ.
3. Нотариатын танхимаас Таны и-мэйл хаягт хэрэглэгчийн нэр болон нууц үг ирнэ **/и-мэйл ирэхгүй тохиолдолд ЕКГ-ын ФБ хуудас эсхүл и-мэйлээр холбогдож нэвтрэх нэр, нууц үгийг хүлээн авах боломжтой/**
4. Шинээр үүсгэсэн өөрийн хаяг руу нэвтэрч орон, явуулах итгэмжлэлийн маягтыг сонгож итгэмжлэлийг иргэн өөрөө боловсруулна.
Итгэмжлэлийг зөвхөн кирилл үсгээр бичнэ үү.

• Үндсэн мэдээллийн хэсэгт доорх зүйлийг анхаарна уу:

- a. Төлөөлүүлэгч нь */Гадаадад байгаа Монгол Улсын иргэн/* гадаадад оршин суугаа хаягаа англи хэл дээр бичиж болно
- b. Төлөөлүүлэгч нь 18 нас хүрсэн Монгол Улсын иргэн байна
- c. Төлөөлөгчийн */Насанд хүрсэн Монгол Улсын иргэн/* оршин суугаа хаягийг кирилл үсгээр бичнэ
- d. Баталгаажуулах Дипломат төлөөлөгчийн газар гэсэн хэсэгт **САН ФРАНЦИСКО хот дахь Ерөнхий консулын газрыг** сонгоно. Хэрэв өөр хотод байрлах ЭСЯ, КГ-ыг сонгосон тохиолдолд тус ЕКГ-ын ажилтанд таны итгэмжлэл харагдахгүй болохыг анхаарна уу.

• Итгэмжлэлээр олгох эрх хэсэгт доорх зүйлийг анхаарна уу:

- a. Эрхүүдийг сонгохдоо нөхөж бичих хэсгийг бүрэн гүйцэт бөглөх
- b. Сонголтоос гадна нэмэлтээр олгох эрхийг **АГУУЛГА** гэсэн хүснэгтэд шивж оруулах

• Бусад нөхцөл хэсэгт доорх зүйлийг анхаарна уу:

Итгэмжлэл нь Иргэний хуулинд зааснаар олгосон өдрөөс **3 хүртэл жил** хүчинтэй байх боломжтой.

• Хавсралт хэсэгт доорх зүйлийг анхаарна уу:

- a. Төлөөлүүлэгчийн хүчин төгөлдөр хугацаатай иргэний үнэмлэх /ар, өвөр/ эсхүл гадаад паспортын хуулбарыг хавсаргах
- b. Итгэмжлэлийн агуулгаас хамааран шаардлагатай бичиг баримтын хуулбарыг хавсаргах.

Ж/нь: үл хөдлөх хөрөнгийн гэрчилгээ, хүүхдийн төрсний гэрчилгээ гэх мэт

• Үйлдэл харах хэсэгт доорх зүйлийг анхаарна уу:

- a. Итгэмжлэлийг сайтар уншиж шалгах

Консулын ажилтан банкны теллер, улсын бүртгэгч биш тул итгэмжлэлээр ямар эрх олгох, агуулгыг холбогдох байгууллагатай холбогдон зөвлөгөө авна уу.

b. Уншиж, хянасны дараа **ХАДГАЛАХ** товчийг дарна

5. Хадгалах товч дарсны дараа "**ДТГ-аар хянуулахаар илгээх үү?**" гэсэн асуултад **ТИЙМ** гэдгийг дарснаар итгэмжлэл Ерөнхий консулын газарт хянуулахаар илгээгдэнэ. Хэрэв **ҮГҮЙ** гэсэн товчийг дарвал хянуулахаар илгээгдэхгүй "Шинэ" гэсэн төлөвт шилжин зөвхөн танд харагдах болохыг анхаарна уу.

ИТГЭМЖЛЭЛ ХЯНУУЛАХААР ИЛГЭЭСНИЙ ДАРАА:

1. Итгэмжлэлийг хянах хугацаа: ажлын 1-2 хоног болно.

2. Консулын ажилтан итгэмжлэлийг хүлээн авч, хянан **ЗӨВШӨӨРСНИЙ** дараа QR code-той итгэмжлэл үүснэ.

QR code-той итгэмжлэлийг "**Миний үйлчилгээ**" цэс рүү орж **БАТАЛГААЖСАН ХҮСЭЛТ** хэсгээс **ШИНЭ** эсхүл **БАТАЛГААЖСАН** төлөвт шилжсэн итгэмжлэлийг **ХАРАХ** товч дээр дарж, хэвлэн авна.

Итгэмжлэлийг хэвлэж авахдаа систем рүү компьютероор нэвтэрнэ үү. Утаснаас хэвлэх боломжгүй.

3. Хэрэв итгэмжлэлийг консулын ажилтан хянан буцаасан тохиолдолд "**Миний үйлчилгээ**" цэс рүү орж **ХЯНУУЛАХ ХҮСЭЛТ** хэсгээс **БУЦААСАН** товч дээр даран буцаасан шалтгааныг уншина

4. **ЗАСАХ** товч дээр дарж итгэмжлэлийг засан дахин хянуулахаар илгээнэ.

ИТГЭМЖЛЭЛИЙГ ЕКГ-Т ИЛГЭЭХИЙН ТУЛД:

a. **ЕКГ-т өөрийн биеэр ирж** QR code үүссэн итгэмжлэл дээр гарын үсэг зуран, төлбөрийг бэлнээр төлж баталгаажуулна.

b. **Өөр хотоос илгээх иргэд:** QR code үүссэн итгэмжлэл дээр гарын үсэг зуран ЕКГ руу 10\$ money order-ийн хамт шуудангаар илгээн баталгаажуулна.

Итгэмжлэлийг хэвлэж авахдаа систем рүү компьютероор нэвтэрнэ үү. Утаснаас хэвлэх боломжгүй.

ИТГЭМЖЛЭЛИЙГ ШУУДАНГААР ИЛГЭЭСНИЙ ДАРАА:

- Гарын үсэгтэй итгэмжлэлийг ЕКГ шуудангаар хүлээн авснаас хойш ажлын 1-2 хоногт архивлана.

"Миний үйлчилгээ" цэс рүү орж **БАТАЛГААЖСАН ХҮСЭЛТ** хэсгээс **АРХИВЛАГДСАН** төлөв рүү шилжсэн итгэмжлэлийн QR code-ийн хажууд гарч буй кодыг Монголд төлөөлөх **ТӨЛӨӨЛӨГЧ** рүү иргэн Та өөрөө илгээнэ. Тус кодыг төлөөлөгч нь дурын нотариатчид өгч, бичиг баримтаа үзүүлэн итгэмжлэлийг хүлээн авах боломжтой.